MERIT
A CESO AND WUSC PROGRAM

Global Affairs Canada
Affaires mondiales Canada

Төсөвлөлт, төсвийн мөчлөг

Эх сурвалж: Гарын авлагын Бүлэг 3-ын 24-38-р нүүр

Агуулга

Төсөв, төсөвлөлт

Төсвийн мөчлөг

Гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт

Эгэх хариуцлага

Төсөвлөлт

- Төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагын эрхлэх асуудлуудын нэг юм.
- Томоохон байгууллагууд (ОУВС, ЭЗХАХБ гм)-ын норм, стандартыг баримталдаг.
- Өнгөрсөн хэдэн арван жилд ихээхэн өөрчлөгдсөн.
- Олон улсын норм, практикт тулгуурласан хэдий ч тухайн улсын онцлогийг тусгадаг.

Төсөв

Төсөв нь төрийн чиг үүргийн хүрээнд тодорхой хугацаанд зорилго, зорилт бүхий цогц арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө юм. Төлөвлөгөө нь шаардлагатай нөөцийн тооцооллыг өмнөх нэг буюу түүнээс дээш тайлант хугацааны гүйцэтгэлтэй харьцуулсан боломжит нөөцийн тооцоолол, ирээдүйд шаардагдах хөрөнгийн хамтаар харуулдаг.

Төсвийн мөчлөгийн үе шат

- Боловсруулж, бэлтгэх;
- Батлах
- Хэрэгжүүлэх
- Тайлагнах, хянаж үнэлэх,

Төрөөс гаргаж буй хүчин чармайлт

Төр төсвийн орлого болон зарлагыг тэнцвэржүүлэхийг чармайдаг. Улсын төсөвт санхүү, нийгэм, эдийн засгийн бодлого ба тэргүүлэх чиглэлийг тоймлон тусгахын зэрэгцээ энд хийгддэг гол тооцоолол нь ирэх жилийн төсвийн зарлагыг дэлгэрэнгүй төлөвлөж оруулдаг.

Зарчим

Нэгдмэл байх – нэгдсэн төсөвт орлого орж, түүнээс зарлага гардаг байх

Бүх нийтийн байх – төсвийн нийт орлого нийт зарлагаа нөхөж байх, өөрөөр хэлбэл, төсөвт оруулсан орлого нь бүх зардлыг ялгаваргүйгээр санхүүжүүлэх нийтлэг санг бүрдүүлдэг.

Жилдээ багтах – төсвийн орлого, зарлагыг санхүүгийн жил, хуанлийн жилээр тооцож зарцуулдаг.

Онцгой тохиолдол

Уругвай Улс Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд батлагдсан нэг төсөвтэй байдаг. Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацааны эхэнд парламентын танхимд төсвөө өргөн барьж, батлуулдаг бөгөөд дараагийн сонгууль хүртэл тухайн төсвийг баримталдаг.

PEFA

Public Expenditure and Financial Accountability

Төсвийн зарлага, санхүүгийн эгэх хариуцлагын хөтөлбөр, төсвийн мөчлөг



Төсвийн зарлага, санхүүгийн эгэх хариуцлагын хөтөлбөрийн 9 шалгуур үзүүлэлт (1)

- Төсөв, төсөв санхүүгийн бодлогын саналд хийх жендэрийн нөлөөллийн дүн шинжилгээ;
- Төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн жендэрийн мэдрэмжтэй менежмент;
- Жендэрийн мэдрэмжтэй төсвийн удирдамж;
- Жендэрийн мэдрэмжтэй төсвийн санал, баримт бичиг боловсруулалт;
- Төрийн үйлчилгээний гүйцэтгэлийн хүйсээр ангилсан мэдээлэл;
- …

PEFA
Public Expenditure and Financial Accountability

Төсвийн зарлага, санхүүгийн эгэх хариуцлагын хөтөлбөрийн 9 шалгуур үзүүлэлт (2)

- …
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангахын төлөөх зарцуулсан төсвийг тусгайлан бүртгэж, тайлагнах;
- Жендэрийн мэдрэмжтэй тайлагнал;
- Төрийн үйлчилгээний жендэрийн нөлөөллийн үнэлгээ;
- Төсвийн жендэрийн нөлөөллийн эрхзүйн (нийцлийн) хяналт шалгалт.

PEFA
Public Expenditure and Financial Accountability

Гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт

Гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт аливаа байгууллагын бүтцийн нэгж бүрийн хувьд зарцуулах нөөц болон үзүүлэх үйлчилгээг хооронд нь уялдуулан тусгадаг.

Дэлхийн улс орнууд татвар төлөгчдөөс цуглуулсан мөнгө болон Холбооны Засгийн газар, төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудын үзүүлж буй үйлчилгээний үр дүнгийн хоорондох уялдаа холбоог харуулахын тулд төрийн байгууллагууд энэ төрлийн төсвийг түгээмэл ашигладаг.

Дэлхий дахинаа адилхан арга хандлага баримталж байна. Энэ нь улс, орон нутгийн аливаа төсөв нь хөтөлбөр, үр дүнд суурилсан удирдлагад тулгуурлаж байвал зохистой гэх санаа юм.

Эгэх хариуцлага

Эгэх хариуцлага нь төсвийг төлөвлөж эхлэхээс эхлээд хэрэгжилтийн төгсгөлд төрийн хяналт шалгалт буюу гүйцэтгэлийн аудит хийж, үр дүнг тайлагнах хүртэл бүх үйл явцыг бүрэн хамарна.

Босоо шатлалтай тогтолцоонд тухайн байгууллага чиг үүргээ гүйцэтгэж байгаа эсэхэд дээд шатны парламентын гишүүд, төрийн хяналтын байгууллага хяналт тавьдаг.

Хэвтээ чиглэлийн эгэх хариуцлага гэдэг нь олон нийт, иргэний нийгмийн байгууллагууд, бусад оролцогч талууд хяналт, үнэлгээнд нь оролцож, үйл ажиллагаанд нь хяналт тавьдаг байна.

Монголын төсөвлөлтийн төлөв байдал

Монгол Улс “хөтөлбөрт төсөвлөлт”-ийн аргыг 2008 оноос туршин хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2013 оноос үндэсний хэмжээнд энэхүү аргыг ашиглан төсвийг төлөвлөдөг болсон юм.

Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль батлагдаж, 2016 оноос хэрэгжиж эхэлснээр урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах болон төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэхдээ үр дүнд суурилсан аргыг ашиглаж байна.

Шалгуур үзүүлэлт Монголд

Монгол Улсын үр дүнд суурилсан төлөвлөлтийн тогтолцоо нь **хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрт бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан чанарын болон тоон үзүүлэлт** хэмээн тодорхойлсон шалгуур үзүүлэлтэд тулгуурласан байдаг.

Гарцын шалгуур үзүүлэлтийг ихэвчлэн байгууллага, бодлого, хөтөлбөр, төслийн үйл ажиллагаанаас шууд бий болох бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын болон тоон үзүүлэлт гэж тодорхойлдог.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт (ЖМТ) гэдэг нь жендэрийн тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсвийн бодлого, удирдамжтай байхыг хэлнэ. Аль ч шатны төрийн байгууллага, түүний төсвийн ерөнхийлөн захирагч нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээг үнэлж, түүнийг харгалзан гол үр дүн, зорилгыг тодорхойлж, төрийн сангийн хөрөнгийг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, энэ тал дээр гаргаж буй ахиц амжилтаа хянаж үнэлэх чадвартай байвал зохино.

Дэлхийн олон орон жендэрийн тэгш байдлыг хангахын тулд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт хийхэд анхаарлаа хандуулж, баялаг арга замыг ашиглах болсон.

PEFA (Төсвийн зарлага, санхүүгийн эгэх хариуцлагын хөтөлбөр) ба ЖМТ

Төсвийн зарлага, санхүүгийн эгэх хариуцлагын хөтөлбөрөөс 2020 онд улс орнуудын төсөв, санхүүгийн удирдлагын жендэрийн мэдрэмжтэй байдлыг үнэлэх нэмэлт механизмыг шинээр боловсруулан гаргажээ.

Уг нэмэлт механизмын дагуу улс орнуудын төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоо нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон эл 2 бүлэг доторх дэд бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ шаардлагыг ямар хэмжээнд харгалзан үзэж, хангаж байгааг үнэлэх зорилгоор зохих мэдээлэл цуглуулж шинжлэхийг дэмждэг юм.

Төсвийн мөчлөгийн үе шатууд, тэдгээрт жендэрийг тусгах

Жендэрийн тэгш байдлыг дэмжихийн тулд төсөв санхүүгийн бодлого, удирдамжийг төсвийн үе шат бүрт ашиглан, жендэрийг тусгаж болно. Тодруулбал:

- Боловсруулж, бэлтгэх
- Батлах
- Хэрэгжүүлэх
- Тайлагнах, хянаж үнэлэх.

Төрийн албан хаагчид төсөвт жендэрийг анхаарч тусгах боломж

Дээрх дөрвөн үе шатны гуравт нь төрийн албан хаагч шууд гар бие оролцож, нөлөөлөх боломжтой. Үүнд:

- Бэлтгэх, боловсруулах
- Хэрэгжүүлэх
- Үнэлэх

Төрийн үйлчилгээг ард иргэдэд тэгш хүртээх байдлыг сайжруулах үүднээс үе шат болгонд хүйсийн тусгайлсан шинжилгээг хийж болох юм.

Монгол Улсын жендэрийн холбогдолтой хууль тогтоомжууд

2011 онд батлагдсан Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (ЖЭТБХТ), түүнийг дагалдан гарсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021), хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө бол Монгол Улсад төрийн бодлого, хөтөлбөр, арга хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах гол баримт бичгүүд юм.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011) нь Үндсэн хуульд заасан эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш эрхийг баталгаажуулж, энэхүү тэгш эрхийг тогтооход байгууллагуудын хүлээх үүрэг хариуцлагын тогтолцоог тодорхойлжээ.

Төрийн санхүүд жендэрийг тусгах

2015 онд Монгол Улсын Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах байгууллага, агентлагийн жендэрийн стратегийн Тэргүүлэх зорилт 3-ыг дараах байдлаар тодорхойлсон байна:

Сангийн сайдын болон зарим төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн үйл явцыг үе шаттайгаар жендэрийн мэдрэмжтэй болгоно.

MERIT
A CESO AND WUSC PROGRAM

Баярлалаа.